



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Ирээдүй сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2026/163/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Архангай аймаг

2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerguibaatard@audit.gov.mn](mailto:Nerguibaatard@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: Шинжлэн Магадлахуй ЭЗШ  
Аудит ХХК-ийн

Гүйцэтгэх захирал С.Оргил

Утас: 99197346

Цахим хаяг: [Info@shinjenmagadlakhui-audit.mn](mailto:Info@shinjenmagadlakhui-audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 85

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Ирээдүй цогцолбор сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,213,753.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, өмнөх оны үлдэгдэл 24,565,2 мянган төгрөг, гүйцэтгэлээр 1,206,378.0 мянган төгрөгийг зарцуулж 31,940.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 үндсэн зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн-захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	24,564,664.3	31,940,303.1
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	24,564,664.3	31,940,303.1
3121	Төгрөг	24,564,664.3	31,940,303.1
31211	Төрийн сангийн харилцах	24,564,664.3	31,940,303.1
33	АВЛАГА	-	1,458,507.1
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,458,507.1
35	БАРАА МАТЕРИАЛ	41,096,290.0	26,904,570.0
354	Хангамжийн материал	41,096,290.0	26,904,570.0
3541	Бичиг хэргийн материал	282,000.0	42,000.0
3542	Аж ахуйн материал	38,564,390.0	22,900,270.0
3544	Түлш, шатах тослох материал	-	828,000.0
3545	Барилгын засварын материал	1,463,000.0	1,463,000.0
3546	Хүнсний материал	786,900.0	1,671,300.0
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	65,660,954.3	60,303,380.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,007,062,429.9	1,005,857,081.7
392	Биет хөрөнгө	965,469,663.1	964,526,314.8
39201	Барилга, байгууламж, орон сууц	930,570,139.6	930,570,139.6
39202	Хуримтлагдсан элэгдэл	(129,300,943.2)	(151,800,586.6)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,000,000.0	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,666,666.7)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,451,066.1	128,415,406.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(52,334,794.2)	(59,609,833.8)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,656,614.1	87,858,004.6
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,155,759.1)	(3,607,446.1)
39214	Бусад үндсэн хөрөнгө	25,225,042.0	25,225,042.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,317,884.7)	(15,837,280.4)
39217	Ном	18,342,849.3	23,312,869.5
393	Биет бус хөрөнгө	41,592,766.8	41,330,766.8
39301	Програм хангамж	2,071,030.0	1,537,500.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(478,263.2)	(206,733.2)
39303	Бусад биет бус хөрөнгө	40,000,000.0	40,000,000.0
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,007,062,429.9	1,005,857,081.7
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,072,723,384.3	1,066,160,461.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	10,776,776.9
413	Өглөг	-	10,776,776.9
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	10,776,776.9
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	10,776,776.9
51	Засгийн газрын хувь оролцоо	1,072,723,384.3	1,055,383,685.0
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	669,870,412.8	669,870,412.8
51101	Өмч: - төрийн	669,870,412.8	669,870,412.8
512	Хуримтлагдсан үр дүн	155,537,803.8	138,198,104.5
5121	Өмнөх үеийн үр дүн	168,335,004.4	168,335,004.4
5122	Тайлант үеийн үр дүн	(12,797,200.6)	(30,136,899.9)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	247,315,167.7	247,315,167.7
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,072,723,384.3	1,055,383,685.0
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,072,723,384.3	1,066,160,461.9

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	983,876,300.0	1,210,966,900.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	873,541,300.0	1,104,658,500.0

**Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ирээдүй сургуулийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл,  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	873,541,300.0	1,104,658,500.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	110,335,000.0	106,308,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	110,335,000.0	106,308,400.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,529,152.7	37,413,103.4
120	Нийтлэг татварын бус орлого	59,529,152.7	37,413,103.4
120009	Бусад орлого		2,786,799.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	48,639,552.7	34,626,304.4
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	10,889,600.0	-
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,043,405,452.7	1,248,380,003.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,044,387,455.4	1,243,303,471.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	971,072,597.8	1,147,552,416.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	681,271,744.5	826,476,633.0
210101	Үндсэн цалин	463,736,580.0	506,920,561.0
210102	Нэмэгдэл	177,749,466.5	262,261,471.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт		11,358,600.0
210104	Урамшуулал	39,785,698.0	45,936,001.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,038,413.5	104,347,492.9
210201	Тэтгэврийн даатгал	59,509,306.0	70,489,592.9
210202	Тэтгэмжийн даатгал	6,943,925.1	8,464,500.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,422,463.2	4,232,200.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,228,281.0	4,232,200.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,934,438.3	16,929,000.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,493,772.4	96,475,255.0
210301	Гэрэл, цахилгаан	17,260,502.0	21,654,955.0
210302	Түлш, халаалт	38,253,500.0	44,505,000.0
210303	Цэвэр, бохир ус	21,979,770.4	30,315,300.0
2105	Нормативт зардал	2,392,500.0	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,392,500.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,437,750.0	14,133,000.0
210604	Урсгал засвар	11,437,750.0	14,133,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,754,930.7	20,109,322.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,754,930.7	20,109,322.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,683,486.7	86,010,712.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,516,577.2	21,065,471.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,449,130.0	7,167,700.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,717,779.5	57,777,541.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,314,857.6	95,751,055.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,322,130.0	95,745,910.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	61,322,130.0	84,894,710.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	10,851,200.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,992,727.6	5,145.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,992,727.6	5,145.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,044,387,455.4	1,243,303,471.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(982,002.7)	5,076,532.2
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,088,136.3	22,416,231.5
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	11,088,136.3	4,494,111.5
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	17,922,120.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(11,088,136.3)	(22,416,231.5)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(12,070,138.9)	(17,339,699.3)

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны (дүн)	Тайлант жилийн дүн
------------	----------	-----------------	--------------------

I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	983,876,300.0	1,213,753,699.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,786,799.0
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,786,799.0
120009	Бусад орлого	-	2,786,799.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	983,876,300.0	1,210,966,900.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	873,541,300.0	1,104,658,500.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	873,541,300.0	1,104,658,500.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	110,335,000.0	106,308,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	110,335,000.0	106,308,400.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	976,899,470.7	1,206,378,060.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	976,899,470.7	1,206,378,060.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	904,384,703.1	1,110,736,115.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	666,811,000.0	826,476,633.0
210101	Үндсэн цалин	435,534,004.0	506,920,561.0
210102	Нэмэгдэл	186,820,457.0	262,261,471.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт		11,358,600.0
210104	Урамшуулал	44,456,539.0	45,936,001.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,351,300.0	105,806,000.0
210201	Тэтгэврийн даатгал	56,679,000.0	71,948,100.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,668,100.0	8,464,500.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,334,000.0	4,232,200.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,334,000.0	4,232,200.0
210205	Эрүүл мэндийн даатгал	13,336,200.0	16,929,000.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,842,272.4	97,303,255.0
210301	Гэрэл, цахилгаан	17,260,502.0	21,654,955.0
210302	Түлш, халаалт	42,602,000.0	45,333,000.0
210303	Цэвэр, бохир ус	21,979,770.4	30,315,300.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,500,000.0	9,000,000.0
210604	Урсгал засвар	16,500,000.0	9,000,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,404,930.7	18,236,100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,404,930.7	18,236,100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,475,200.0	53,914,127.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,483,000.0	48,855,527.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,992,200.0	5,058,600.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,514,767.6	95,641,945.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,522,040.0	95,636,800.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,522,040.0	84,785,600.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	10,851,200.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,992,727.6	5,145.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,992,727.6	5,145.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,976,829.3	7,375,638.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	6,976,829.3	7,375,638.8
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	24,564,664.3
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	31,940,303.1

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
4-01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	669,870,412.8	247,315,167.7	155,537,803.8	1,072,723,384.3
4-08	Тайлант үеийн үр дүн			(30,136,899.9)	(30,136,899.9)

4-01	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	669,870,412.8	247,315,167.7	138,198,104.5	1,055,383,685.0
------	--------------------------------------	---------------	---------------	---------------	-----------------

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,235,697,300.0	1,210,966,900.0	24,730,400.0	98
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,129,388,900.0	1,104,658,500.0	24,730,400.0	97.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,129,388,900.0	1,104,658,500.0	24,730,400.0	97.8
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	106,308,400.0	106,308,400.0	-	100
132001	Орон нутгийн төсвөөс	106,308,400.0	106,308,400.0	-	100
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	24,565,200.0	-	24,565,200.0	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	24,565,200.0	-	24,565,200.0	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,260,262,500.0	1,213,753,699.0	46,508,801.0	96.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,235,697,300.0	1,206,372,915.2	29,324,384.8	97.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,139,894,300.0	1,110,736,115.2	29,158,184.8	97.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	850,871,600.0	826,476,633.0	24,394,967.0	97.1
210101	Үндсэн цалин	573,958,500.0	506,920,561.0	67,037,939.0	88.3
210102	Нэмэгдэл	255,346,000.0	262,261,471.0	(6,915,471.0)	103
210103	Унаа хоолны хөнгөлөлт		11,358,600.0	(11,358,600.0)	
210104	Урамшуулал	21,567,100.0	45,936,001.0	(24,368,901.0)	213
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,724,200.0	105,806,000.0	918,200.0	99.1
210201	Тэтгэврийн даатгал	72,572,500.0	71,948,100.0	624,400.0	99.1
210202	Тэтгэмжийн даатгал	8,538,000.0	8,464,500.0	73,500.0	99.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,268,900.0	4,232,200.0	36,700.0	99.1
210204	Ажилгүйдлийн даатгал	4,268,900.0	4,232,200.0	36,700.0	99.1
210205	Эрүүл мэндийн даатгал	17,075,900.0	16,929,000.0	146,900.0	99.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,308,400.0	97,303,255.0	5,145.0	100
210301	Гэрэл, цахилгаан	22,993,100.0	21,654,955.0	1,338,145.0	94.2
210302	Түлш, халаалт	44,000,000.0	45,333,000.0	(1,333,000.0)	103
210303	Цэвэр, бохир ус	30,315,300.0	30,315,300.0	-	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,000,000.0	9,000,000.0	-	100
210604	Урсгал засвар	9,000,000.0	9,000,000.0	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,632,300.0	18,236,100.0	396,200.0	97.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,632,300.0	18,236,100.0	396,200.0	97.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,357,800.0	53,914,127.2	3,443,672.8	94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,299,200.0	48,855,527.2	3,443,672.8	93.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,058,600.0	5,058,600.0	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	95,803,000.0	95,636,800.0	166,200.0	99.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,803,000.0	95,636,800.0	166,200.0	99.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	84,951,800.0	84,785,600.0	166,200.0	99.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,851,200.0	10,851,200.0	-	100
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,235,697,300.0	1,206,372,915.2	29,324,384.8	97.6
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	24,564,664.3	(24,564,664.3)	

31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	31,940,303.1	(31,940,303.1)	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0		100
3	Төсвийн байгууллага	1.0	1.0		100
4	Төсвөөс гадуур байгууллага	1.0	1.0		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.0	28.0		100
6	Удирдах ажилтан	4.0	2.0	2.0	50
7	Гүйцэтгэх ажилтан	32.0	32.0		100
8	Үйлчлэх ажилтан	20.0	9.0	11.0	45
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	268.0	268.0		100
11	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	268.0	268.0		100
12	Төрийн өмчит ЕБС	268.0	268.0		100

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 67,970.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар акталсан хөрөнгийн элэгдэл 67,970.0 мянган төгрөгийг хасаагүйгээс үндсэн хөрөнгийн үлдэгдлийг зөрүүтэй тусгасныг аудитын явцад залрууллаа. Энэ нь НББ-ын тухай хуулийн 5.1.4, 13.1, 14.4.1, 15.1, 15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Залруулаагүй 4,258.35 мянган төгрөгийн зөрчилд<sup>2</sup> илэрч 2 албан шаардлага хүргүүлээ. Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг зөрчил нь 4,258.4 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 13,996.13 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

3.1.1. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2,799,850 төгрөгийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс аваагүй, бусад этгээдээс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "ерөнхий гэрээний арга" гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"; 9 дүгээр зүйлийн 9.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ", 38 дугаар зүйлийн 38.1-т "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.1.2. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 1,458,507.11 төгрөгийн авлагатай тайлагнагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулж ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Цахим худалдан авалттай холбоотой	1	2,799.9			1	2,799.9				
Авлагатай холбоотой	1	1,458.5			1	2,799.9				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>4,258.4</b>	-	-	<b>2</b>	<b>4,258.4</b>			-	-